



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ХЯРГАС НУУР-ЗАВХАН ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒3 оны 04 сарын 13 өдөр

Дугаар ᠑/᠐8

Улиастай

Ус ашиглах зөвшөөрөл  
олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29 дүгээр зүйлийн 29.1, Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2023 оны 03 сарын 14-ний өдрийн 41 дугаар тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Завхан аймгийн Завханмандал суманд орших MV-021001 тоот тусгай зөвшөөрөл бүхий “Шувуун хар уул” ХХК нь 2023 онд ажилчдын унд ахуйн хэрэгцээнд 8,170.2 м<sup>3</sup>/жил, технологийн хэрэгцээнд 30,000.0 м<sup>3</sup>/жил, зам талбайн тоосжилт дарахад 10,800.0 м<sup>3</sup>/жил, биологийн нөхөн сэргээлт ногоон байгууламж, мод услахад 4,286.0 м<sup>3</sup>/жил, уурхайн өрөмдлөгт ашиглах 18,029.6 м<sup>3</sup>/жил ус ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. “Шувуун хар уул” ХХК-тай ус ашиглах гэрээ байгуулахыг Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн /Ц.Отгонбилэг/-д даалгасугай.

3. Дараах арга хэмжээг авч ажиллахыг ус ашиглагч “Шувуун хар уул” ХХК-ны гүйцэтгэх захирал /Г.Золбаяр/-д үүрэг болгосугай.

3.1 Ахуйн бохир усыг “Хаягдал ус, Ерөнхий шаардлага” MNS4943:2015 стандартын шаардлагад нийцүүлэн байгальд нийлүүлэх;

3.2 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах;

3.3 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангах;


3.4 Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлж, ус ашиглалтын тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнаж байх;

4.Энэхүү тушаал болон ус ашиглах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Т.Даваажаргал/-д даалгасугай.

ДАРГА



Э.ЗОЛ-ОД



### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 04 сарын  
13 -ны өдөр

Дугаар 02

Завхан аймаг, Улиастай сум

#### Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1-д -д заасны дагуу “Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” Усны газрын 2023 оны 03-р сарын 14-ны өдрийн 41 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2023 оны 04 дугаар сарын 13 -ний өдрийн А/08 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргааны Усны барилга байгууламж, үйлдвэр хөдөө аж ахуйн, ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн Цаваандорж овогтой Отгонбилэг

1. Ус ашиглагчийг төлөөлж: Завхан аймгийн Завханмандал сумын төвөөс баруун хойш 58 км, Улиастай хотоос баруун зүгт 210 км, Улаанбаатар хотоос 1200 км зайтай оршино. 9011200089 улсын бүртгэл, 5320607 регистрийн дугаартай “Шувуун хар уул” ХХК–н гүйцэтгэх захирал Гадиг овогтой Золбаяр нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

#### Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологийн усны хэрэгцээнд:

2.2. Ашиглах усны хэмжээ: нийт 72,635.8 м<sup>3</sup>/жил

2.2.1	Технологийн ус	30,000.0	м <sup>3</sup>
2.2.2	Зам талбайн усалгаа	10,800.0	м <sup>3</sup>
2.2.3	Унд ахуйн хэрэгцээ	8170.2	м <sup>3</sup>
2.2.4	Биологийн нөхөн сэргээлт	4,286.0	м <sup>3</sup>
2.2.5	Тэрбум мод үндэсний Хөдөлгөөн	1,350.0	м <sup>3</sup>
2.2.6	Уурхайн өрөмдлөгт ашиглах	18,029.6	м <sup>3</sup>

“Шувуун хар уул” ХХК-ийн 2023 онд ашиглах усыг газрын доорх өрөмдмөл худгуудаас авч ашиглана.

№	Худгийн нэр	X	Y	Худгийн гүн	Ундарга л/с
1	Худаг 1	94° 40' 14.80"	48° 14' 21.10"	83	2.0
2	Худаг 2	94° 40' 36.10"	48° 14' 26.90"	65	3.0

2.2.5 үйлчилгээ, м<sup>3</sup>/жил \_\_\_\_\_ Хамааралгүй

2.2.6 эмчилгээ, сувилгаа, хүн/жил \_\_\_\_\_ Хамааралгүй

### 2.3. Усны чанар, найрлага:

Уурхайн үйлдвэрлэлийн талбайн ашиглалты худгуудын усны чанарын шинжилгээг улирал бүр шинжлүүлж байх,

Шинжилгээний дүнг улирал бүр манай сав газрын захиргаанд ирүүлэх

### 2.4. Усны эх үүсвэрийн:

**Байршил:** Уурхайд Баянхайрхан талбайн зүүн уулын Харанхуйн амнаас нийт гүний 2 ш худаг ашиглана.

**Барилга байгууламж:** Өрөмдмөл худаг

Тоног төхөөрөмжийн нэр, марк : **Худаг-1**

QJD-7.5-100-3 маркийн насостой

Тоног төхөөрөмжийн нэр, марк : **Худаг-2**

QJD-7.5-100-3 маркийн насостой

Нийт усан сангийн багтаамж: 3000 м<sup>3</sup>

Тоног төхөөрөмжийн нэр, марк:

25PNJ маркийн насостой

Үйлдвэр дотроо 18,000 м<sup>3</sup> багтаамжтай ус хуримтлуулах 2 сан (эргэлтийн сан)

### 2.5. Хаягдал усны:

**Хэмжээ:** Унд ахуйн хэрэгцээнд нормоор тооцоход жилд 10,296.0 м<sup>3</sup> ус хэрэглэж, хэрэглээнээс гарах бохир усыг бага оврын цэвэрлэх байгууламжаар цэвэрлэж, ногоон байгууламжийн усалгаанд ашиглуулахаар Усны газрын дүгнэлтэд заасны дагуу цэвэрлэгээг хийсэн байх

**Стандартын шаардлага:** Хаягдал усыг "Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи түвшинд тавих үндсэн шаардлага" (MNS 4288-95)-ыг хангасан цэвэрлэх байгууламжид ариутгаж цэвэршүүлсэн байх, Цэвэрлэсэн хаягдал ус нь "Дахин ашиглах цэвэрлэсэн ус" стандартын шаардлага

(MNS 6734:2018)-ыг хангасан байх

Солбилцол: N .....°.....'....." E .....°.....'....." - цэвэрлэх байгууламжийн байршил буй хаягдал ус зайлуулах цэг бичих

### 2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ. Усны биохимийн шинжилгээний дүнг хавсаргана.

Жинлэгдэх бодис, кг \_\_\_\_\_

Органик бодис, кг \_\_\_\_\_

Эрдэсбодис, кг \_\_\_\_\_

Хүнд металл, кг \_\_\_\_\_

Аюултай бохирдуулах бодис, гр \_\_\_\_\_

### 2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд зааснаар, ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламжийн цэвэрлэх чадварыг сайжруулж, саарал усны чанарыг стандартад нийцүүлэх

#### 2.7.1. Шар усны болон гэнэтийн үерийн ус уурхайн ухлагад буюу ашиглалт явуулж буй талбайд орохоос сэргийлж, зохих арга хэмжээ авах

Баяжуулахад ашиглаж буй химийн бодис гадаад орчинд алдагдахаас сэргийлэх арга хэмжээ авах

Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор Усны газар болон сав газарт ирүүлэх шаардлагатайг анхаарах

**2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:**

- ✓ Унд-ахуйн усны эх үүсвэрт ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож, журамлах, ус тээвэрлэхэд зориулалтын машин, ус хадгалах ган ашиглах
- ✓ Тосгон болон үйлдвэрлэлийн ажлын үед гарах ахуйн бохир усыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, бохир усны цэвэршилтийн зэргийг хянах зорилгоор усанд хими, бактериологийн шинжилгээг тогтмол хийж байх
- ✓ Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, усны бохирдол, усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах /улирал бүр/
- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг тухайн оны онцлог байдалд тохируулан нарийвчлан төлөвлөн хэрэгжүүлж байх.
- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд 2023 онд 35,110 сая төгрөг, үүнээс усны бохирдол, нөлөөллийг бууруулахад зориулж 12,3 сая төгрөг тусгасан байна.
- ✓ Уурхайн шавхалтын усыг зөвхөн уурхайн дотоодын замын тоосжилтыг дарах зориулалтаар ашиглах.
- ✓ Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах.
- ✓ Ашиглалтын 1-р худгийн хажууд газрын доорх усны түвшин хэмжилт, усны шинжилгээний дээж авах зорилгоор мониторингийн цооног гаргаж тоноглох, дата мэдээлэл үүсгэх.
- ✓ Сав газрын захиргаа болон Завханмандал сумын байгаль хамгаалагч, БОХУ-н байцаагч, Шувуун хар уул ХХК-н мэргэжилтнүүд нарыг байлцуулан цэвэр усны тоолуурын заалт, 12-р сарын 10-ны байдлаар дуусгавар болгон баталгаажуулж, дараа оны 1-р сарын 1-с хойшхи заалтыг тайлант оны ус ашиглалтын мэдээ тайланд оруулж байх.
- ✓ Ашиглалтын худгаас авч буй усыг бүртгэлжүүлж бүртгэлийн дэвтрэийг хөтөлж, баталгаажуулан ажиллах.
- ✓ Ашиглалтын худгуудыг тоолууржуулах, тоолуурийн бүрэн бүтэн байдал байнга хяналт тавьж ажиллах. Сар бүр тухайн сумын Байгаль хамгаалагч, БОХУ-н байцаагч нараар тоолуурын заалтын бичилт хийж акт үйлдэж зургаар баталгаажуулах.
- ✓ Завханмандал сумын малчдын худаг болох Луусын худаг болон Улаан түмбэнгийн худгуудад иж бүрэн засвар үйлчилгээ хийх. ˆ
- ✓ Ус ашиглалтын тайлан мэдээг улирал бүр ирүүлэх, мөн жилийн эцсийн тайланг 12-р сарын 15-ны дотор ирүүлж гэрээг дүгнүүлэх.
- ✓ Сав газрын захиргаа болон Завханмандал сумын байгаль хамгаалагч, БОХУ-н байцаагч, Шувуун хар уул ХХК-н мэргэжилтнүүд нарыг байлцуулан цэвэр усны тоолуурын заалт, 12-р сарын 10-ны байдлаар дуусгавар болгон баталгаажуулж, дараа оны 1-р сарын 1-с хойшхи заалтыг тайлант оны ус ашиглалтын мэдээ тайланд оруулж байх.
- ✓ Хаягдал усыг цэвэршүүлэх бага оврын цэвэрлэх байгууламж барих.
- ✓ Булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хамгарч хийх

## 2.9. Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар: Худаг - 1  
Тоолуурын дугаар: 202101016  
Загвар: LXSG  
Тоолуурын тоо: 1  
Суурилуулсан байгууллага, огноо: 2022.03.03 Амь-Ус Трейд ХХК  
Баталгаажуулсан байгууллага, огноо: 2024.03.03  
Тоолуурын заалт: 0267 м<sup>3</sup>  
2023 оны 04-р сарын 12-ний заалт  
Төрөл, нэр, дугаар: Худаг - 2  
Тоолуурын дугаар: 202101024  
Загвар: LXSG  
Тоолуурын тоо: 1  
Суурилуулсан байгууллага, огноо: 2022.09.23  
Баталгаажуулсан байгууллага, огноо: 2024.09.23  
Тоолуурын заалт: 1840  
2023 оны 04-р сарын 12-ний заалт

## 2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

### 2.10.1. Технологийн ус хэрэглээ:

$2716 \times 1.8 = 4888.8$  /итгэлцүүр/  
 $30,000.0 \text{ м}^3 \times 4888.8 = 146,664,000$  ₮  
 $146,664,000 \text{ ₮} \times 0.35 = 51,332,400$  ₮

### 2.10.2. Зам талбайн усалгаа

$2716 \times 0.3 = 814.8$  ₮  
 $10,800.0 \text{ м}^3 \times 814.8 = 87,998,400.0$  ₮  
 $87,998,400.0 \text{ ₮} \times 0.2 = 1,759,968.0$  ₮

### 2.10.3. Биологийн нөхөн сэргээлт

$2716 \times 0.25 = 679$  ₮  
 $4,286.0 \text{ м}^3 \times 679 = 2,910,194$  ₮  
 $2,910,194 \text{ ₮} \times 0.1 = 291,019.4$  ₮

### 2.10.4. Өрөмдлөгт усны нөөц ашигласны төлбөр

$2716 \times 1.7 = 4617.2$  ₮  
 $18,029.6 \times 4617.2 = 83,246,269.1$  ₮  
 $83,246,269.1 \text{ ₮} \times 0.2 = 16,649,253.82$  ₮

**Нийт төлбөр:**  $51,332,400 + 1,759,968.0 + 291,019.4 + 16,649,253.82 = 70,032,641.0$   
/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу ундахуйд жилд ашиглах  $8,170.0 \text{ м}^3$  усыг төлбөрөөс чөлөөлнө.  
Завхан аймгийн Төрийн сангийн дансанд төвлөрүүлэх

## Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.

4.5.3. ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

4.5.4. байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн;

4.5.5. ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй;

4.5.6. усны эх үүсвэрийг бохирдуулсан;


4.5.7. усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

4.5.8. сав газрын захиргааны шийдвэрээр;


4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

  
/Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны Усны барилга байгууламж, ус ашиглалт хариуцсан мэргэжилтэн Цаваандорж овогтой Отгонбилэг/

Ус ашиглагчийг төлөөлж:

  
/“Шувуун харуул” ХХК-н гүйцэтгэх захирал Гадиг овогтой Золбаяр /

Харилцах утас: 89098282

Харилцах утас: 88177645